



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/184

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Хөнөгийн голд гүүр барих ажлын гүйцэтгэлийн явцад хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
Д.Пүрэвсүрэн (иргэний төлөөлөл)

2. Ажлын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Дэмиддагва)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С. АМГАЛАН